



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2022 оны 10 сарын 25 өдөр

Дугаар A/67

Улаанбаатар хот


Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн өмчит болон төрийн оролцоотой компани, төрийн өмчит үйлдвэрийн газрын 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг хэлэлцэн санал дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг хавсралтад заасны дагуу байгуулсугай.

2.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, үйлдвэрийн газрын 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг хэлэлцэн, 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор санал дүгнэлт боловсруулах, 2022 оны 12 дугаар сард багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулан шийдвэрлүүлэхийг ажлын хэсэг /Ц.Баяр-Эрдэнэ/-т даалгасугай.

ДАРГА




Б.ЦЭНГЭЛ

132013338

ТӨБЗГ тушаал-/2022

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын даргын 2022 оны 10 дүгээр сарын
25 -ны өдрийн А/67 дугаар тушаалын
хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ахлагч

Ц.Баяр-Эрдэнэ – Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга

Гишүүд:

Н.Ганболд - Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга

В.Дарханбаатар - Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн Удирдлага,
төлөөллийн албаны дарга

Ц.Шинэхүү - Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн Төлөвлөлт,
хөрөнгө оруулалтын албаны дарга

Э.Ганчимэг - Төрийн өмчийн хяналт, шалгалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Д.Тунгалагтуул - Төрийн өмчийн бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Б.Янжинлхам – хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Б.Амарбаясгалан Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн
мэргэжилтэн